



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудит
Аудитын код: БНА-2019/132/СТА-ТШЗ



Баянхонгор
2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор: Ж.Өсөхбаяр

Утас: 99890393 Цахим хаяг: usukhbayar_j@yahoo.com

Цахим хуудас: www.audit.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ЗДТГ-ЫН	Засаг даргын Тамгын газар

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал	10
3.1	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл.....	10
3.1.1	Илрүүлэлт:.....	10
3.1.2	Эрсдэл:.....	10
3.1.3	Өгсөн зөвлөмж:.....	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ц.НАСАНБАЯР ТАНАА

2019.02.22 № 12/40
танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын

E:\Usukhuu\STA-2019\8.Баянхонгор сум ЗДТГ\4.Тайлагнал\Аудитын гэрчилгээ.docx

2519058

систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

E:\Usukhuu\STA-2019\8.Баянхонгор сум ЗДТГ\4.Тайлагнал\Аудитын гэрчилгээ.docx

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Баянхонгор сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ЗДТГ-ын дарга Ц.Насанбаярд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын ЗДТГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 15-наас 2019 оны 02 дугаар сарын 19-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор сумын ЗДТГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор сумын ЗДТГ нь “Өндөр мэдлэг, ур чадвартай зарчимч мэргэшсэн, төрийн албан хаагчдыг үр дүнтэй, тогтвортой ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж, сумын удирдлагад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, сумын нийгэм эдийн засгийн хөгжлийн бодит нөхцөлд шинжилгээ хийж, иргэддээ үйлчлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баянхонгор сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн олон талт цогц үйлчилгээ хүргэн, төрийн удирдлагыг нээлттэй, ил тод, шуурхай байлгах
- Эрх зүйн сургалт, сурталчилгааг тогтмолжуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэн, гадаад орны болон бусад аймгийн ижил төрлийн байгууллагуудтай тогтоосон хамтын ажиллагааг сум /хот/-ын хөгжил рүү чиглүүлэх
- Төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадвар, туршлагыг дээшлүүлэн хүний нөөцийн хөгжлийг хангах

Баянхонгор сумын ЗДТГ-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор сумын ЗДТГ-ын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан

бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор сумын ЗДТГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянхонгор сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор сумын ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор сумын ЗДТГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Баянхонгор сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1461127.3 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 29222.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа, зөрчилтэйд тооцох асуудал гараагүй болно.

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Байхгүй

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Тайлант онд цалингийн зардлаас ажлаас чөлөөлсөн 2 ажилтны цалин, нийгмийн даатгалын шимтгэлд 3969.8 мянган төгрөгийг шүүхийн шийдвэрийг үндэслэн шилжүүлсэнд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлэхээр 2019 онд төлбөрийн акт тогтоосон байна.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор сумын ЗДТГ-ын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1082315.4 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1081712.9 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь 2018 онд 1082315.4 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулан 602.5 мянган төгрөг хэмнэгдсэнтэй холбоотой байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор сумын ЗДТГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Тус байгууллага нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”-аар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 24 мэдээллийг хугацаанд нь, 6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 179 гүйлгээг хугацаанд нь тус тус мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна..

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор сумын ЗДТГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

3.1.1 Илрүүлэлт:

Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан 9.6 сая төгрөгийн зардал нь “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам" -ын 2.1 “Засаг даргын нөөц хөрөнгийг дор дурьдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

"Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ыг мөрдөөгүйгээс төсвийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах, төсвийн үрэлгэн зардал гарах

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам" –ыг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 04 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	78,203,127.34	74,633,481.47
33	АВЛАГА	00.00	164,913.93
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	164,913.93
35	БАРАА МАТЕРИАЛ	78,203,127.34	74,468,567.54
354	Хангамжийн материал	73,273,127.34	71,353,567.54
35410	Бичиг хэргийн материал	8,237,315.00	12,789,535.00
35420	Аж ахуйн материал	29,548,064.80	21,189,453.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,852,465.60	5,136,465.60
35470	Бусад хангамжийн материал	31,635,281.94	32,238,113.94
35600	Мал амьтад	4,930,000.00	3,115,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,215,581,315.22	1,177,024,179.36
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,215,581,315.22	1,177,024,179.36
392	Биет хөрөнгө	1,209,297,468.06	1,104,175,179.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,630,252,456.77	1,018,630,823.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	-554,685,549.72	-94,143,982.77
39203	Авто-тээврийн хэрэгсэл	44,401,936.00	133,701,936.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-38,496,190.71	-46,252,102.48
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	128,166,801.00	122,036,123.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-95,118,904.11	-90,135,576.62
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	100,900,991.58	105,635,299.58
39208	Хуримтлагдсан элэгдэл	-46,733,026.81	-45,297,340.43
39214	Бусад үндсэн хөрөнгө	51,792,641.00	00.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-11,183,686.94	00.00
393	Биет бус хөрөнгө	6,283,847.16	72,848,999.98
39301	Програм хангамж	1,670,000.00	1,920,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-870,000.00	-1,195,000.02
39303	Бусад биет бус хөрөнгө	6,079,466.00	72,124,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-595,618.84	00.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,293,784,442.56	1,251,657,660.83
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	217,740.00	2,254,913.93
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	217,740.00	2,254,913.93
413	Өглөг	217,740.00	2,254,913.93
4136	Бусад өглөг	217,740.00	2,254,913.93
41361	Байгууллагад төлөх өглөг	217,740.00	1,090,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	1,164,913.93
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,293,566,702.56	1,249,402,746.90
51	Засгийн газрын хувь оролцоо	1,293,566,702.56	1,249,402,746.90
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	804,585,433.09	876,709,433.09
51101	Өмч: - төрийн	804,585,433.09	876,709,433.09
512	Хуримтлагдсан үр дүн	195,180,166.18	2,513,526.10
51210	Өмнөх үеийн үр дүн	195,180,166.18	195,180,166.18
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-192,666,640.08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	293,801,103.29	370,179,787.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,293,784,442.56	1,251,657,660.83

4.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	869,749,730.00	1,268,460,707.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,034,400.00	15,412,932.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,034,400.00	15,412,932.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,034,400.00	15,412,932.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,551,000.00	1,100,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,483,400.00	14,312,932.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	864,715,330.00	1,253,047,775.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	183,638,934.00	157,225,199.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	183,638,934.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	157,225,199.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	652,981,800.00	1,082,615,430.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	652,981,800.00	1,082,615,430.00
1330	Төсвийн захирагчдаас	21,403,358.00	00.00
133003	Хөрөнгийн	21,403,358.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	6,691,238.00	13,207,146.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	6,691,238.00	13,207,146.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	926,297,993.69	1,205,668,830.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	926,297,993.69	1,205,668,830.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	912,595,995.69	1,104,429,137.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	312,777,909.35	397,656,556.94
210101	Үндсэн цалин	312,777,909.35	397,656,556.94
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,575,730.37	47,590,160.54
210201	Тэтгэврийн даатгал	22,437,529.41	31,904,254.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,922,882.50	4,984,860.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,535,414.09	2,696,996.87
210204	Ажилгүйдлийн даатгал	607,264.03	750,979.58
210205	Эрүүл мэндийн даатгал	6,072,640.34	7,253,069.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,243,641.00	59,393,149.00
210301	Гэрэл, цахилгаан	3,227,553.00	4,646,813.00
210302	Түлц, халаалт	28,796,648.00	52,599,716.00
210303	Цэвэр, бохир ус	1,219,440.00	2,146,620.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,789,466.77	54,392,193.67
210401	Бичиг хэрэг	5,262,830.00	12,356,770.00
210402	Тээвэр, шатахуун	7,590,000.00	14,940,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,229,470.97	8,449,391.87
210404	Ном, хэвлэл	45,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	531,055.00	2,722,320.00
210408	Бараа материал акталсны зардал	11,131,110.80	15,743,711.80
2105	Нормативт зардал	00.00	230,000.00
210502	Хоол, хүнс	00.00	230,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,512,210.00	10,999,600.00
210604	Урсгал засвар	2,512,210.00	10,999,600.00
2107	Томилолт, зочны зардал	1,019,000.00	894,500.00
210702	Дотоод албан томилолт	1,019,000.00	894,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	397,446,987.52	417,122,233.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	397,446,987.52	417,122,233.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	101,231,050.68	116,150,743.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,863,700.04	43,313,840.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,010,900.00	2,675,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	58,356,450.64	70,161,903.86

Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,701,998.00	101,239,693.65
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	77,199,900.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	77,199,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,701,998.00	17,382,146.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	6,691,238.00	13,207,146.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,010,760.00	4,175,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	2,002,547.65
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,002,547.65
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	4,655,100.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,655,100.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-56,548,263.69	62,791,876.34
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	16,561,999.73	255,458,516.42
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	16,561,999.73	250,262,420.62
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	5,196,095.80
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-16,561,999.73	-255,458,516.42
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-73,110,263.42	-192,666,640.08

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	898,630,572.00	1,254,147,775.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,551,000.00	1,100,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,551,000.00	1,100,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,551,000.00	1,100,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,551,000.00	1,100,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	896,079,572.00	1,253,047,775.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	183,638,934.00	157,225,199.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	183,638,934.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	157,225,199.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	705,749,400.00	1,082,615,430.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	705,749,400.00	1,082,615,430.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	6,691,238.00	13,207,146.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	6,691,238.00	13,207,146.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	878,495,223.40	1,128,901,775.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	878,495,223.40	1,128,901,775.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	864,793,225.40	1,082,543,081.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	318,479,400.00	395,298,117.48
210101	Үндсэн цалин	318,479,400.00	395,298,117.48
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,031,600.00	49,948,600.00
210201	Тэтгэврийн даатгал	35,031,600.00	33,958,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	3,997,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	3,198,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	799,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	7,994,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,761,673.00	59,690,349.00
210301	Гэрэл, цахилгаан	3,227,553.00	4,944,013.00
210302	Түлш, халаалт	25,743,020.00	52,599,716.00
210303	Цэвэр, бохир ус	791,100.00	2,146,620.00

Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	18,897,066.40	41,804,901.87
210401	Бичиг хэрэг	5,503,380.00	15,941,040.00
210402	Тээвэр, шатахуун	7,590,000.00	14,224,000.00
210403	Шуудан, холбоо, ингернэтийн төлбөр	5,196,131.90	8,527,791.87
210404	Ном, хэвлэл	90,000.00	190,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	517,554.50	2,922,070.00
2105	Нормативт зардал	00.00	150,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	150,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,631,805.00	14,159,600.00
210602	Тавилга	5,506,000.00	00.00
210604	Урсгал засвар	23,125,805.00	14,159,600.00
2107	Томилолт, зочны зардал	1,019,000.00	894,500.00
210702	Дотоод албан томилолт	1,019,000.00	894,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	357,388,804.00	485,370,873.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	357,388,804.00	485,370,873.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,583,877.00	35,226,140.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	74,420,977.00	32,551,140.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,162,900.00	2,675,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,701,998.00	46,358,693.65
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	22,318,900.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	22,318,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,701,998.00	17,382,146.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	6,691,238.00	13,207,146.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,010,760.00	4,175,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	20,135,348.60	125,246,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	125,246,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	125,246,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	125,246,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	125,246,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-125,246,000.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	804,585,433.09	293,801,103.29	195,180,166.18	1,293,566,702.56
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	804,585,433.09	293,801,103.29	195,180,166.18	1,293,566,702.56
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	76,378,684.42	00.00	76,378,684.42
D08	Тайлант үеийн үр дүн	72,124,000.00	00.00	-192,666,640.08	-120,542,640.08
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,709,433.09	370,179,787.71	2,513,526.10	1,249,402,746.90

Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,064,312,100.00	1,057,302,302.76	1,082,315,400.00	1,081,712,882.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,064,312,100.00	1,057,302,302.76	1,082,315,400.00	1,081,712,882.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,013,486,900.00	1,012,062,349.76	930,351,800.00	929,972,982.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	423,367,200.00	422,462,259.04	395,359,900.00	395,298,117.48
210101	Үндсэн цалин	423,367,200.00	422,462,259.04	395,359,900.00	395,298,117.48
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,545,500.00	46,545,500.00	49,948,600.00	49,948,600.00
210201	Тэтгэврийн даатгал	46,545,500.00	46,545,500.00	33,958,900.00	33,958,900.00
210202	Тэтгэмжийн даатгал			3,997,400.00	3,997,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал			3,198,000.00	3,198,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал			799,500.00	799,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал			7,994,800.00	7,994,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,258,200.00	53,128,976.00	59,861,200.00	59,690,349.00
210301	Гэрэл, цахилгаан	4,564,800.00	4,464,723.00	5,114,300.00	4,944,013.00
210302	Түлш, халаалт	47,118,400.00	47,118,413.00	52,602,600.00	52,599,716.00
210303	Цэвэр, бохир ус	1,575,000.00	1,545,840.00	2,144,300.00	2,146,620.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,070,900.00	30,701,140.72	41,821,300.00	41,804,901.87
210401	Бичиг хэрэг	8,460,800.00	8,887,330.00	15,604,000.00	15,941,040.00
210402	Тээвэр, шатахуун	13,625,300.00	13,625,320.00	14,224,000.00	14,224,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,399,400.00	6,448,286.22	8,499,400.00	8,527,791.87
210404	Ном, хэвлэл	320,000.00	475,000.00	320,000.00	190,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд	1,265,400.00	1,265,204.50	3,173,900.00	2,922,070.00
2105	Нормативт зардал	700,000.00	700,000.00	150,000.00	150,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	700,000.00	700,000.00	150,000.00	150,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	70,495,000.00	70,484,374.00	14,190,000.00	14,159,600.00
210602	Тавилга	41,519,700.00	41,519,700.00	00.00	00.00
210604	Урсгал засвар	28,975,300.00	28,964,674.00	14,190,000.00	14,159,600.00
2107	Томилолт, зочны зардал	4,013,600.00	4,009,000.00	940,000.00	894,500.00
210702	Дотоод албан томилолт	4,013,600.00	4,009,000.00	940,000.00	894,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	346,244,500.00	346,244,500.00	332,825,600.00	332,800,774.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	346,244,500.00	346,244,500.00	332,825,600.00	332,800,774.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,792,000.00	37,786,600.00	35,255,200.00	35,226,140.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,302,000.00	36,302,000.00	32,560,000.00	32,551,140.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,490,000.00	1,484,600.00	2,695,200.00	2,675,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,825,200.00	45,239,953.00	151,963,600.00	151,739,900.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	147,763,600.00	147,564,900.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	00.00	147,763,600.00	147,564,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,825,200.00	45,239,953.00	4,200,000.00	4,175,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал	50,825,200.00	45,239,953.00	4,200,000.00	4,175,000.00

Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,064,312,100.00	1,057,302,302.76	1,082,315,400.00	1,081,712,882.35
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
		1,062,011,900.00	1,055,002,102.76	1,081,215,400.00	1,080,612,882.35
132001	Орон нутгийн төсвөөс	1,062,011,900.00	1,055,002,102.76	1,081,215,400.00	1,080,612,882.35
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС				
		2,300,200.00	2,300,200.00	1,100,000.00	1,100,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос	2,300,200.00	2,300,200.00	1,100,000.00	1,100,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО				
		68.00	68.00	63.00	64.00
620001	Удирдах ажилтан	03.00	03.00	03.00	03.00
620002	Гүйцэтгэх ажилтан	51.00	51.00	51.00	52.00
620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00	09.00	09.00